



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 230

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, тус аймгийн Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр, Чагдаржавын гудамж 3-300а хаягт байрших 4809005455 нэгж талбарын дугаар бүхий, төрийн үйлчилгээний зориулалттай 4900 м.кв талбайтай, 58,800,000.00 (тавин найман сая найман зуун мянган) төгрөгийн балансын үнэ бүхий газар эзэмших эрхийг Дундговь аймаг дахь Шүүхийн Тамгын газрын эзэмшилд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын дарга А.Энхманлай, Дундговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Чагнаадорж, Дундговь аймаг дахь шүүхийн Тамгын газын дарга А.Лхагвасүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайландаа тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.3. Шилжүүлж буй газрын эзэмших эрхийг эрх бүхий этгээдээр шинэчлэн баталгаажуулж, бүртгэх, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т хүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТАЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ
133830776
10-r huraldaan.docx